Химийн бодисын аюулгүй ажиллагаа, түүнийг зөрчсөнтэй холбоотой осол аваар нь голдуу химийн бодис зөөвөрлөх машин, техникийн бүрэн бүтэн байдал, аюулгүй ажиллагааны горим алдагдсанаас үүдэлтэй байдаг. Химийн хортой болон аюултай бодисыг тээвэрлэх болон устгах үеийн аюулгүй ажиллагаа зөрчигдсөнөөс болон ургамлын нөмрөг, ургамалжилтад үзүүлэх сөрөг нөлөөлөл илүү байна. Иймээс химийн бодис тээвэрлэх, хадгалах журамд заагдсаны дагуу алдаж асгахаас сэргийлэх арга хэмжээ авах

3.1.6. Хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ

- Химийн бодисын агуулахын барилгын хийц, инженерийн байгууламжийн төлөвлөлт, гүйцэтгэлийн доголдлоос үүдэн аюул, осол гарахаас байнга урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, агуулахын бүрэн бүтэн байдалд байнгын хяналт тавих.
- Химийн бодисын агуулахад ажиллаж буй мэргэжилтэн нь хор аюулын лавлах мэдээлэлд заасан хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг хангаж ажиллахаас гадна химийн бодис алдагдахаас урьдчилан сэргийлсэн бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүлэх, асгарч алдагдсан тохиолдолд түүнийг саармагжуулах арга хэмжээг авах чадварыг эзэмшсэн байх.
- Аюулгүй ажиллагааны зааварчилгааг өөрийн байгууллагын Гүйцэтгэх захирлын тушаалаар батлуулан ажлын байр болон агуулахад химийн бодистой харьцаж ажилладаг ажилтан өдөр

тутмын ажиллагаанд ашиглаж байх боломжтой харагдахуйц газарт байрлуулах бөгөөд аюулгүй ажиллагааны зааварчилгаанд химийн бодисын хор аюул, үүсэж болох эрсдэл /хүний эрүүл мэнд, байгаль орчин/, химийн бодистой харьцах, хадгалах зааварчилгаа, асгарч алдагдсан болон галын аюулын үед авах арга хэмжээ, анхны тусламж, хувийн хамгаалах хэрэгсэл, хэрэглэх заавар, хаягдлыг устгах зааварчилгааг зэргийг багтаасан байна.

- Ажлын байран доторх бага хэмжээтэй химийн бодис хадгалах зөөврийн агуулахыг шат, аврах гарц, хонгилын эргэлтийн өнцөг, давчуу хонгил гэх мэт хүмүүсийн хөдөлгөөнд саад учруулах эрсдэлтэй газарт хадгалахгүй байх.
- Химийн хорт болон аюултай бодис тээвэрлэх, хадгалахтай холбоотой үйл ажиллагааг хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны нөхцөл, шаардлагыг бүрэн хангасан зориулалтын байр, талбайд явуулахаас гадна болзошгүй аюул, осол гарсан үед хүний эрүүл мэнд, эд хөрөнгө, байгаль орчинд үүсэх хохирлыг бууруулах зорилгоор авч хэрэгжүүлэх үйл ажиллагаа, түүний дарааллыг тогтоосон “Аюул, ослын үед ажиллах төлөвлөгөө” боловсруулж, тухайн орон нутгийн Онцгой байдлын газраар батлуулсан хэрэгжүүлэх.
- Химийн бодистой харьцаж ажилладаг ажиллагсдыг үүсэж болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх, түүнийг хянах, эрсдэл үүссэн тохиолдолд хариу арга хэмжээ авах мэдлэг, дадлыг эзэмшүүлэх сургалтад заавал хамруулсан байх.
- Химийн бодисын агуулахын болзошгүй аюул, ослын үед ашиглах, хор аюулын лавлах мэдээлэлд заасны дагуу бүрэн ажиллагаатай гал унтраах багаж, хэрэгсэл, хор саармагжуулах бодис, уусмал, химийн бодис асгарч алдагдсан үед ашиглах багаж, хэрэгсэл, шингээгч материал, хувийн хамгаалах хэрэгсэл (арьс, нүд, амьсгал хамгаалах), амьсгал хамгаалах баг, шаардлагатай тохиолдолд нүд угаах болон ослын шүршүүр зэргийг ажлын байранд байршуулж, ажиллагсдад ажиллах дадлыг эзэмшүүлэх.

3.1.7. Химийн бодис материал алдагдсан үед авах арга хэмжээ

“Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам”-ын 2.1.2-д химийн бодистой ажиллах аюулгүй ажиллагааны зааварчилгааг үйлдвэрлэгчээс гаргасан ХАЛМ-д үндэслэн боловсруулж өөрийн байгууллагын даргаар батлуулсан байх ёстой хэмээн заасан байдаг. Мөн журмын 2.1.5-д болзошгүй аюул, ослын үед авч хэрэгжүүлэх үйл ажиллагаа, төлөвлөгөө боловсруулж, тухайн орон нутгийн онцгой байдлын газраар батлуулсан байна хэмээн заасан байдаг.

Тус химийн бодисын агуулах нь нь одоогоор үйл ажиллагаа хэвийн явагдаж байгаа бөгөөд үйл ажиллагааг эхлэхээс өмнө аюулгүй ажиллагааны зааварчилгаа, аюул ослын үед авч хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөж батлуулах шаардлагатай байна. Аюул ослын үед авч хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөж боловсруулахад дараах зөвлөмжүүдийг тусгах хэрэгтэй. Үүнд:

Их хэмжээгээр ус, хөрсөнд алдагдсан тохиолдолд “Орон нутгийн онцгой байдлын алба”-нд мэдээлэл яаралтай хүргэж, тархах хүрээг хумих боломжит арга хэмжээг авч, pH-ийг өсгөх, саармагжуулах зорилгоор шингээж авахаар модны үртэс дээр нь нэмнэ.

Бодис материалууд их хэмжээгээр ус, хөрсөнд алдагдсан тохиолдолд “орон нутгийн онцгой байдлын алба”-нд мэдээлэл яаралтай хүргэж, дээрх аргуудаар осол аюулын зэрэглэлийг бууруулах шаардлагатай бөгөөд аюул ослын үед авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар холбогдох байгууллагуудад тайлагнах шаардлагатай. Ус хөрсөнд бодис материал алдагдсан эсэхийг Мэргэжлийн хяналтын байгууллагаар шалгуулж холбогдох дүгнэлтийг гаргуулах, алдаа зөрчлийг арилгасны дараа үйл ажиллагааг дахин эхлүүлэх шаардлагатай байна.

3.1.8. Химийн бодисын хаягдлыг хадгалах тогтворжуулах

Тус компанийн технологийн горим алдагдах, алдаа гарах зэргээс хамаарч чанарын шаардлага хангахгүй бүтээгдэхүүн гологдол үүсэх боломжтой. Ийм тохиолдолд гологдол бүтээгдэхүүн буюу

химийн бодисыг устгах шаардлага тулгарна. МУ-ын хувьд химийн хортой аюултай хаягдлыг устгах, боловсруулах, булшлах байгууламж байхгүй тул гологдол бүтээгдэхүүнийг түр хадгалах шаардлага тулгарна. Технологиос үзвэл органик болон органик бус хаягдал гарах боломжтой. Ийм

хаягдлыг технологийн хяналт бүхий шатаалтад оруулж устгах нь тохиромжтой байна. Шатаах боломжтой энэхүү хаягдлыг 1мз багтаамжтай хоосон саванд битүүмжлэн түр хадгалж “Химийн хортой аюултай хаягдлыг устгах, боловсруулах, булшлах байгууламж”-д нийлүүлэх шаардлагатай.

3.1.9. Химийн бодисын хадгалалт, агуулахыг тохижуулах

Химийн бодисын агуулах нь гэрэлтүүлэг, агааржуулалт сайтай байсан. Мөн Тус тусад нь хадгалах зориулалтын тасалгаа гаргаж өгсөн байсан. Шалыг нь битүү цементээр хийсэн байсан.

“Химийн хортой болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулахын барилгад тавих ерөнхий шаардлага” MN 6458:2014-ийн 5.11-д агуулахын агааржуулалтын талаар зааж өгсөн байх тул уг заалтын дагуу агуулахуудыг агааржуулах шаардлагатай. Химийн бодисын хоосон сав баглаа боодлыг устгалт оруулах хүртэл хуримтлуулж түр хадгалах бөгөөд үүнд зориулж агуулахын тодорхой хэсэгт зай талбай гаргах нь зүйтэй юм. Агуулахад бодис материалыг хадгалж эхлэхтэй зэрэгцэн тус стандартын 3-р бүлэгт заасны дагуу тэмдэг тэмдэглэгээг гүйцэтгэх, стандартын бусад заалтуудыг биелүүлэх.

3.1.10. Удирдлага, зохион байгуулалтын талаар

“Химийн хортой болон аюултай бодисын тухай” Монгол улсын хууль Химийн хортой болон аюултай бодисыг импортлох, экспортлох, хил дамжуулан тээвэрлэх болон үйлдвэрлэх худалдах журам, Химийн хортой болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх ашиглах устгах журам, зэрэг хууль, журам тогтоол дүрэм зэргийг нарийн баримталж ажиллах.

Тусгай зөвшөөрөл бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллага химийн хортой болон аюултай бодис худалдахдаа худалдан авсан этгээдийн хаяг, бодисын нэр, төрөл, хэмжээ, ашиглах зориулалтыг заасан баримтыг 2 хувь үйлдэн баталгаажуулж нэг хувийг худалдан авагчид, үлдсэн хувийг өөртөө хадгална.

Хадгалж байгаа химийн хорт болон аюултай бодисын сав баглаа боодол нь тухайн бодисын нэр, анхааруулах тэмдэг аюулын шинж чанарыг тод, томоор бичсэн шошготой байна.

Химийн бодисын ашиглалт, зарцуулалтын тайланг БОУАӨЯ-нд жил бүрийн 11 дүгээр сарын 15-ны дотор гаргаж өгнө.

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 10^1 дүгээр зүйлийн дагуу 2 жил тутамд байгаль орчны аудит хийлгэж байх.

Жил бүр байгаль орчны менежментийн төлөвлөгөө батлуулж түүнийгээ биелүүлэн 11 сарын 1 гэхэд биелэлтийн тайлан хийж дүгнүүлэн ажиллах.

А. Орчныг бохирдлоос хамгаалах талаар

Химийн бодис, материалыг тээвэрлэхдээ зохих байгууллагаас зөвшөөрөл авч шаардлага хангасан сав, баглаа боодолтой, хагарч асгарч гэмтэхээргүй зөөлөвч жийрэгтэйгээр, нийтэд сэрэмжлүүлсэн таних тэмдэг, анхааруулсан тод бичигтэйгээр зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ.

Химийн онцгой хортой, хортой бодисын санамсаргүй алдагдал гарсан тохиолдолд хорыг саармагжуулах, ариутгал цэвэрлэгээ хийх талаар яаралтай арга хэмжээ авч хэрэгжүүлэх , зааварчилгааг бодис нэг бүрээр гаргаж компанийн ажиллагсдад эзэмшүүлэх.

Б. Ажиллагсдын эрүүл ахуйг хамгаалах, хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах талаар

Агуулахын байрны агаар дахь химийн хор аюултай бодисын агуулга, температур, чийгшил, тоосжилтын түвшин зэрэгт хяналт тавих багаж хэрэгсэлтэй болох арга хэмжээг ойрын үед авах.

Ажиллагсдад химийн бодис, материалыг ачих, буулгах, зөөх үедээ ажлын тусгай хувцас, техник хэрэгслийг ашиглан хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрмийн шаардлагыг нарийн баримтлан ажилладаг дадал зуршлыг хэвшүүлэх.

Онцгой нөхцөлийн үед ашиглах хөдөлмөр хамгааллын тусгай хувцас, багаж, техник хэрэгслийн зохих нөөцийг бүрдүүлэх.

В. Сургалт судалгааны талаар

Тус компанийн стратегийн болон ойрын зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн технологийн менежмент (сургалт, сурталчилгаа, орчны хяналт)-ийг хөгжүүлэх, удирдлагын байгаль орчин, эрүүл

ахуйн талаарх мэдээллийг сайжруулах.

Компанийн ажиллагсдад зориулсан байгаль орчин, үйлдвэрлэлийн экологийн талаар сургалтын хөтөлбөр боловсруулж, мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах.

Химийн бодис, материалын агуулахын үйл ажиллагааг хэвийн явуулах, аливаа гэмтэл, ослоос урьдчилан сэргийлэх аргын үндэс болсон хөдөлмөр хамгааллын зааварчилгааг тогтмол өгч мөрдөлтөд нь байнга хяналт тавьж байх.

Хаягдал, бохирдолд тавих байгаль орчны салбарын олон улсын нормативыг технологийн үйл ажиллагааны дамжлага тус бүр дээр мөрдөж ажиллах, орчны хяналт шинжилгээг жил бүр тогтоосон хугацаанд хийлгэж хэвших.

Агааржуулалтын систем

Ажлын байранд үүсэж байгаа уур, хий, тоосны хортой нөлөөллийг бүх талаар багасгах үндсэн хэрэгсэл бол тоног төхөөрөмжийн шаардлагатай бүх хэсгүүдэд бүрэн бүтэн байдлыг хангах, автоматжуулах, алсын удирдлагатай системээр тоноглох, хортой уур, хий, тоосыг яг үүссэн газраас нь зайлуулж оронд нь цэвэр агаар оруулах замаар хортой нөлөөллийг дотогшоо сорох агаартай холилдон хий, тоосыг зайлуулах орчинд гадагшаа сорох зохих хурд бий болгосноор ажлын бүсэд бий болсон хорт бодисуудыг байранд тархахаас сэргийлнэ. Хэсэгчилсэн гадагшаа сорох агааржуулалтыг ажлын байран дээр бий болсон хортой ба аюултай ялгарлуудыг ажлын байрны агаар луу алдагдах явдлыг зайлшгүй арилгах тохиолдолд хэрэгжүүлнэ. Харин дотогшоо сорох хэсэгчилсэн агааржуулалтыг гол төлөв ажилчдыг дулаацуулах, мөн хэт халууцуулах зорилгоор ажиллуулдаг ба агаараар үлээх эдгээр төхөөрөмжийг суурин ба зөөврийн гэж ангилдаг. Агаараар үлээх эдгээр төхөөрөмжөөр агаарын урсгалын чиглэлийг хэвтээ буюу бага зэрэг налуулж үлээлгэх ба энэ нь ажилчны биеийг ажлын байрнаас гарсан хортой бодисын үлээлтийн замд оруулахгүй байхаар төлөвлөж байгаа байдал юм. Мөн ийм аргаар агааржуулалт хийж байгаа үед ажлын байрыг хэт халалтаас болгоомжилж, хэвийн температурыг барих ёстой.

Осол аюулын үеийн агааржуулалтыг ажлын бүсэд гэнэт их хэмжээний хортой бодис (тоосноос гадна) ялгарч болзошгүй тохиолдолд ажиллуулахаар зэхсэн байх ёстой. Осол аюулын үеийн агааржуулалт ямагт гадагшаа сорох зарчмаар ажилладаг тул бохир агаарыг зайлуулна. Осол аюулын үеийн агааржуулалтаар гадагшаа зайлуулсан хортой бодисууд нь хүмүүсийн тогтмол ажлын байр ба бусад газруудад хохирол учруулахааргүй байвал зохино. Осол аюулын үеийн агааржуулалтыг хортой бодисуудын зөвшөөрөгдөх концентратын хэмжээнд тохируулсан хийг задлан шинжлэх аппараттай автомат горимоор ажиллахаар холбоно. Үүнээс гадна ослын үед гарсан хорт бодисуудыг зайлуулах агааржуулалтыг ажиллуулах асуудлыг байран дотроос ч бас гаднаас ч алсын удирдлагаар шийдвэрлэх боломжтой байлгах ёстой.

Гадна агаарыг байранд оруулахын өмнө тусгай агаар цуглуулан цэвэрлэх (шүүх) төхөөрөмжөөр дамжуулна. Тэр нь дотогшоо сорох системд агаартай хамт элдэв хөнгөн хольц атмосферийн тунадас сорогдон орохоос хамгаалсан хөшиг, шүүлттэй байдаг. Дотогшоо оруулах цэвэр агаар хүлээн авах цэг газрын түвшнээс дээш 2-2.5м-ийн өндөрт байх ёстой. Харин дотроос гаргасан бохир агаар, дотогшоо оруулах цэвэр агаартай холилдохоос сэргийлэн цэвэр агаар хүлээн авах, бохир агаар гадагшаа үлээх цэгүүд хоорондоо 10м-ээс доошгүй зайтай байхаас гадна хооронд нь 5-8м-ийн өндөртэй босоо хаалт байрлуулах шаардлагатай. Түүнчлэн цэвэр агаар хүлээн авах цэг ямагт салхины дээд талд байрлахаар дотогшоо ба гадагшаа сорох системүүдийг зохицуулан байрлуулна.

Гэрэлтүүлэг

Ажилтны шинжилгээ хийх, химийн бодис хадгалахаас бусад ажлын байруудыг байгалийн гэрэл нэвтрэх боломжоор хангасан байх ба ажиллагсдын аюулгүй ажиллагаа болон эрүүл ахуйд нийцсэн нэмэлт гэрэлтүүлэг байрлуулсан байх шаардлагатай. Нэмэлт гэрэлтүүлэг тусгайлан шаардагдах ажлын байруудад зохих шаардлагуудыг хангахуйц гэрэлтүүлэг тавина. Гэнэтийн үед буюу ажлын байрны цахилгаан хангамж саатаж гэрэлтүүлэг унтарсан, эвдэрсэн болон нүүлгэн

шилжүүлэх шаардлага гарсан үед өөрөө асах автоматчилагдсан гэрэлтүүлгүүдийг ажлын байруудад зохих газруудад байрлуулна.

Анхны тусламж

Төсөл хэрэгжүүлэгч анхны тусламж үзүүлэх мэргэжилтнийг үйл ажиллагааны бүхий л хугацаанд байнгын бэлэн байдалд ажиллуулна. Зохих шаардлагын дагуу бүрэн бүрдүүлсэн анхны тусламжийн хайрцгийг ажлын байрны тохиромжтой газар бүрд байрлуулах ба бүх ажилчид дор хаяж анхны тусламжийн талаарх анхан шатны мэдлэгтэй болсон байх шаардлагатай. Явуулж буй үйл ажиллагааны төрөл, цар хүрээнээс хамаарч тэдгээрт тохирсон анхны тусламжийг үзүүлэхэд тохиромжтой байдлаар тоноглоно. Анхны тусламж үзүүлэх хэсэг болон өрөөнүүдэд бээлий, нөмрөг, амны хаалт зэргийг байрлуулж, цус болон хүний биеийн бусад шингэнээр элдэв халдвар дамжихаас сэргийлнэ.

Цахилгаан

Цахилгааны тоног төхөөрөмжүүдийн тухайлбал, хэлхээ таслагч, хяналтын самбар, кабель, утаснууд, гар багаж зэргийн нөлөөлөлд өртөх ажилчдад ноцтой эрсдэл учруулж болно. Тиймээс доорх арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхийг зөвлөж байна. Үүнд:

- Цахилгааны бүх тоног төхөөрөмжүүд, шугамуудад анхааруулсан тэмдэг байрлуулах
- Цахилгааны бүх утас, кабель болон цахилгаан гар багажуудын утас ил гарсан, шалбарсан эсэхийг шалгах, зөөврийн гар багажуудыг ашиглаж болох цахилгаан хүчдэлийн зөвшөөрсөн дээд хэмжээг дагаж мөрдөх
- Чийгтэй орчинд ажиллах бүх цахилгаан тоног төхөөрөмжид давхар тусгаарлалт, газардуулга хийх зэрэг болно.

3.2. Техник, технологийн арга хэмжээ

Үйлдвэрийн үйл ажиллагаатай уялдуулан дараах төлөвлөлтүүдийг авч хэрэгжүүлэх Үүнд:

- Ногоон технологи ашиглах
- Ногоон байгууламж байгуулах

3.2.1 Ногоон технологи ашиглах тухай зөвлөмж

Монгол улсын их хурлын 2014 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан Ногоон хөгжлийн бодлогын 3.1.2-т "Ногоон барилгын үнэлгээний систем, эрчим хүчний аудит зэрэг ногоон шийдэл, эрчим хүчний хэмнэлттэй, дэвшилтэт технологи, стандартыг нутагшуулан нэвтрүүлж, эдгээрийг дэмжих урамшуулал, хөнгөлөлтийн механизмыг хэрэгжүүлж, барилгын дулааны алдагдлыг 2020 онд 20 хувь, 2030 онд 40 хувиар тус тус бууруулах" гэж заасан бөгөөд тус бодлогод ногоон барилга гэж хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд сөрөг нөлөөгүй материал ашигласан, дулааны алдагдал хамгийн бага байх хийцтэй, агаарт ялгаруулах хаягдал багатай халаалтын шийдэлтэй, эрчим хүч, нөөцийн хэмнэлт үр ашигтай, хур тунадасны усыг хуримтлуулж ашиглах, хаягдал бохир усаа цэвэрлэж зайлуулах технологи бүхий, тав тухтай орчныг бүрдүүлсэн барилга байгууламжийг хэлнэ гэж тодорхойлсон байна.

Энэхүү нөхцөлийг хангасан барилга, байгууламж барьж байгуулахад дараах технологийг нэвтрүүлэх шаардлагатай юм.

- Гадаад гудамж талбайн гэрэлтүүлэгт нар, салхины бага чадлын эх үүсвэрээр ажилладаг гэрэлтүүлэг суурилуулах
- Дулаан алдагдлыг бууруулах технологийг судлан барилга, байгууламжид нэвтрүүлэн дулаан алдагдлыг 20-30% хүртэл бууруулах

3.2.2 Ногоон байгууламж байгуулах

Ногоон байгууламжийн төлөвлөгөөг боловсруулахдаа Засгийн газрын 2021 оны 350 дугаар тогтоолын хавсралт “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ ажлын хүрээнд манай компани 30ш мод тарихаар төлөвлөж байна.

Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх хуулийн дагуу газар эзэмшигч нь эдэлбэр газрын 20-аас доошгүй хувийг ногоон байгууламжтай байлгах шаардлагатай байдаг.

Ургамлын нөмрөгийг хамгаалах, нөхөн сэргээх нь төслийн үйл ажиллагаанаас ургамлын

нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, тус нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй бусад аж, ахуй нэгж, байгууллагыг энэ ажилд татан оролцуулснаар эрчимтэй явагдаж буй цөлжилтийн үйл явцыг сааруулах ач холбогдолтой болох юм.

Ногоон байгууламж нь ариун цэвэр, гоо сайхны үнэлж баршгүй ач холбогдолтой бөгөөд агаарын бохирдол, таагүй нөхцөлийг бууруулж хүний тохь тухтай, эрүүл амьдрах орчныг бүрдүүлдэг байна. Ногоон байгууламж нь орчныг тоос шорооноос цэвэрлэх байгалийн шүүлтүүр болдог. Агаарын бохирдлоос хамгаалах, тоосыг өөртөө шингээх чадамж нь зуны улиралд 30%, өвөл 37% болохыг судлаачид тогтоожээ.

Зүлэг тарих зөвлөмж

1. Талбайгаа зүлэгжүүлэхийн өмнө шим тэжээл муутай газрын хөрсийг 20-30 сантиметр гүн хагалж хайрга чулууг цэвэрлэж аваад үлдсэн шороог зөөсний дараа хүрэн хөрсийг 2.5х2.5 сантиметрийн гишгүүрээр гишгэж, ургамлын үндэс болон бусад хогноос цэвэрлэж, гишгэсэн хар хүрэн хөрсийг 20 сантиметрээс доошгүй зузаан дэвсэж гадаргууд жигд тарааж тэгшилснээр зүлэг тарих талбай бэлэн болно.
2. Үрийг нэг метр квадрат талбайд 50-80 грамм орохоор тооцоолж салхи багатай тогтуун өдөр талбайд жигд цацаад тармууруар самнасны дараа элсээр нэгээс хоёр сантиметр зузаан хучна.
3. Үүний дараа 50-100 килограмм жинтэй булаар булдаж зөөлөн шүршиж усална.
4. Зүлэгжүүлэх ажлыг тавдугаар сарын хоёрдугаар хагасаас долоодугаар сарын 10-нд багтааж тарьдаг байна.
5. Тарьсан сэрүүнд талбайд гандуу үрээ соёолтол хөрсийг нь чийгтэй нэг метр квадрат 20-30 литр ус орохоор бодож долоо үед өдөр байлгахын тулд өдөр бүр 30-40 литр ус, үр соёолсноос хойш нэг хоногт гурваас дөрвөн удаа бүр өглөө оройн метр квадрат услах бөгөөд услах хэрэгтэй.

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчныг хамгаалах талаар хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх, тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулах, түүнийг хянан батлах, хэрэгжилтийг ханган тайлагнахтай холбогдсон харилцааг БОАЖСайдын 2019 оны 10-р сарын 29-ны өдрийн А/618 тоот Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журмыг баримтлан хийж гүйцэтгэлээ.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь дараах хэсгүүдээс бүрдэнэ. Үүнд: Сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ (агаарын чанар, гадаргын болон газрын доорх усны нөөц хөрсөн бүрхэвч, газрын хэвлий, ургамлын нөмрөг, амьтны аймгийг хамгаалах, хуримтлагдах нөлөөллийн үнэлгээгээр тогтоогдсон арга хэмжээ болон тухайн орон нутгийн нийгэм эдийн засгийн хөгжлийг дэмжихэд чиглэсэн арга хэмжээг тусган), нөхөн сэргээх арга хэмжээ (техникийн болон биологийн нөхөн сэргээлт), биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ, түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээ химийн хортой болон аюултай бодисын эрсдэлийг бууруулах арга хэмжээ хог, хаягдлын менежментийн арга хэмжээ, орон нутгийн захиргаа, аймаг нийслэлийн байгаль орчны газар, ажлын хэсгийн дүгнэлт, шаардлагаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ, нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах үйл ажиллагаа, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр орно.

Аймаг нийслэлийн байгаль орчны газар тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг хэвлэмэл болон цахим хэлбэрээр хүлээн авсан талаарх мэдээллийг байгаль орчны менежментийн төлөвлөгөөний цахим мэдээллийн санд оруулж, хүлээн авсан тухайгаа төсөл хэрэгжүүлэгчийн бүртгүүлсэн цахим шууданд ажлын 5 хоногт багтаан хариу мэдэгдэнэ.

Хөрөнгө санхүүгийн эх үүсвэр: Жил бүрийн санхүүгийн төлөвлөгөөний байгаль орчны болон ажиллагсдын эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээний зардалд тусган зарцуулж байх шаардлагатай. Төлөвлөсөн зардлын хэмжээ нь тухайн жил бүр харилцан адилгүй тогтоогдох боломжтой тул тухай бүрд нь тодруулга хийж шинэчлэн тооцно.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ

Төсөл хэрэгжүүлэгч ажиллагсдын ажиллах орчин, хөдөлмөр хамгаалал, химийн бодисын эрсдэлийн менежментийн асуудал дээр гол анхаарлаа хандуулж, 2007 оны 04 дугаар сарын 27-ний өдрийн 151/126/52 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Химийн хорт болон аюултай бодисыг хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам”, МК8 4585-2016. Агаар орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага, М^8 6458:2014. “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, Химийн хорт болон аюултай бодис бүтээгдэхүүний агуулах”, БНбД 21-04-05. Барилга байгууламжийн гал унтраах

автомат төхөөрөмж, дохиоллын хэрэгсэл, М^8 5566:2005. Аж ахуйн нэгж байгууллагад зайлшгүй байх гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн шаардлага зэрэг стандартуудыг нарийн баримтлан ажиллаж, тухайн бодисын хор аюулгүйн лавлах мэдээлэл (М8^8)-д заагдсаны дагуу химийн бодис бүртэй харьцаж ажиллах

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд гарах зардал/төг

Д/д	Бүрэлдэхүүн хэсгүүд	2026 оны жилийн зардал /төг/
1.	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	1,362,500
2.	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө /ногоон байгууламжийн төлөвлөгөө/	302,500
3.	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
4.	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	-
5.	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
6.	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	512,500
7.	Удирдлага зохион байгуулалт	5,812,500
8.	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	2,700,000
9.	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	840,000
Нийт		**11,530,000**

Сөрөг нөлөөллийг* бууруулах*, арилгах, арга хэмжээний төлөвлөгөө.

Гол ба болзошгүй сөрөг нөлөөллүүд	**Урьдчилан сэргийлэх, буУРУУлах багасгах арга хэмжээ**	**Арга хэмжээний цар хүрээ**	**Нэгжийн өртөг /Мян.төг/**	**Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж**	**Баримтлах хууль журам стандарт**
1.Агаар орчны асуудлаар					
Агуулах болон үйлдвэрийн хөрсний элэгдлээс үүдэлтэй тоосжилт болон химийн бодисынууршилтын үр дүнд ялгарах хий зэрэг нь агаарын тоосжилт ба бохирдолтыг тодорхой хэмжээгээр нэмэгдүүлэх эх үүсвэр болно.	Агааржуулалтын систем холбох, шүүлтүүр тавих	Агуулах болон үйлдвэртээ	200,0	2026он	М\8 0012-013:1991. Ажлын байрын агаар. Ажлын байрны агаарын бүс
	Агуулахын тоосжилт, чимээ шуугиан, чийгшил, гэрэлтүүлгийн байдлыг сайжруулах		100,0	2026он	МЫ817.2.3.16-88. ”Хот суурин газрын агаарын чанарыг хянах журам
	Орчны болон ажлын байрын агаарын бохирдлын байдалд шинжилгээ хийлгэх (жилд 1 удаа)		ОХШХ-т тусгасан	2026он	УСТ3384-82”. Агаар мандлын сорьц авахад тавих ерөнхий шаардлага
Нийт			**300,0**		
2Дуу чимээ					
Ашиглагдаж буй машин, тоног төхөөрөмжөөс үүссэн дуу чимээ орчны шуугианы түвшнийг бууруулах.	Машин тоног төхөөрөмжийг дуу шуугиан хамгийн бага тарах нөхцөлтэйгөөр байршуулан ашиглах	Үйлдвэрийн газар дотор болон химийн бодис ачиж буулгахдаа	100,0	2026он	М\8 180 226:2003 дуу чимээ - хэвийн норм-түвшний хэмжээ М\8 5002:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй.
	Ажиллагсдыг дуу шуугианаас хамгаалах хэрэгслээр хангаж хэрэгжүүлэх	Ажиллагсад	50 хүн * 5,0 = 250,0	2026он	
	Дуу шуугианы хэмжилт (1 цэгт дууны түвшин хэмжигч Нк-04 багажаар) хийх,	Үйлдвэрийн газар дотор болон гаднах талбайд	30,0 х 1 удаа х 3 цэгт = 90,0	2026он	Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага
Нийт			**640,0**		
3. Хөрсөн бүрхэвчийн асуудлаар					

Химийн бодисын санамсаргүй алдагдал, ахуйн хог хаягдлыг зориулалтын цэгт төвлөрүүлж графикт хугацаанд ачиж зайлуулахгүй байх зэрэг нь хөрснийг бохирдуулна.	-Бодисыг их хэмжээгээр асгарахаас болгоомжилж үргэлжийн хянуур ажиллах -Асгарсан тохиолдолд М8Э8-Д заасны дагуу яаралтай арга хэмжээ авах. -Хүнсний сод, элс, шороо, вермикулитыг бэлэн байлгах	Агуулах орчимд	100,0	2026он	МЫ8 3307:1991, МЫ8 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойолох арга, МЫ8 5850:2019 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
Химийн бодис тээвэрлэх ачиж буулгах Хөрс элэгдэж эвдрэл орно Мөн хүн, машины хөдөлгөөний улмаас агуулахын орчмын хөрс элэгдэлд орно. Үйлдвэрийн түүхий эд болон бэлэн болсон зүйлийг ачиж тээвэрлэх үед	Өөрийн эзэмшлийн талбайгаас төв гол зам хүртэлх замыг хайрган хучилтай болон хатуу хучилттай болгох	Төслийн орчимд	УАЗ	2026он	
Нийт			**100,0**		
4.Газрын доорхусны асуудал					
Төслийн явцад усыг их хэмжээгээр, замбараагүй хэрэглэсэн тохиолдолд усны нөөцөд шууд нөлөөлөх магадлалтай	Усыг ариг гамтай хэрэглэх дэвшилт технологи ашиглах арга хэмжээ авах, мэдрэгчтэй крант бочки тавих	Төслийн хүрээнд	350,0	2026он	-Байгаль орчныг хамгаалах тухай хууль, - Усны тухай хууль Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль
	Тоолуурын заалтын дагуу ус ашигласаны төлбөрийг төлөх		УАЗ		
	Ус бохирдуулсны төлбөр төлөх		УАЗ		
Нийт			**350,0**		
Нийт дүн			**1390,0**		
5. Удирдлага зохион байгуулалтын талаар					
Энэхүү тайлангийн сөрөг нөлөөллийг бууруулах зөвлөмжүүдийг үйл ажиллагаандаа тусгаж хэрэгжүүлэх		Үйлдвэрийн ажилчдад	-		Компанийн дотоод журмаар
Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх дохиоллын системийг сайжруулах			100,0	2026 он	

Ажиллагсдыг жилд 1 удаа галын аюулаас урьдчилан сэргийлэх зорилгоор сургалт явуулах		250,0	2026 он	

Химийн бодистой ажиллах аюулгүй ажиллагааны сургалт тогтмол зохиож байх		300,0	2026 он	
Ажиллагсдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах,		90,400 *50 хүн = 4,520,000	2026 он	
Ажиллагсдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэглэлээ бүрэн хангах		1,000,000	Жил тутамд	
Ажлын байранд аюулгүйн шүршүүр болон нүд угаах зориулалтын угаалтууртай болгох		УАЗ	2026 он	
Нийт дүн		**6,170,000**		

Ногоон байгууламж байгуулах төлөвлөгөө /ургамлын нөмрөг хамгаалах/

“Блюскай кашемир” ХХК-ийн төслийн онцлогоос хамааран ногоон байгууламжийн төлөвлөгөөг боловсруулахдаа Засгийн газрын 2021 оны 350 дугаар тогтоолын хавсралт “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ ажлын хүрээнд төсөл хэрэгжүүлэгчийг үйлдвэрийн орчны ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, цэцэрлэгжүүлэлтийг сайжруулах үүднээс мод тарих ажлыг оруулсан. Ногоон байгууламж байгуулах зөвлөмжийг төслийн БОННҮ-д тодорхой тусгаж зардлын тооцоог гаргасан ба энэхүү зардлыг төслийн бүтээн байгуулалтын төсөвт суулгаж өгөх нь зүйтэй.

Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө /ургамлын нөмрөг хамгаалах/

Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээх арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг /мян.төгрөг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Төслийн орчинд, ногоон байгууламж бий болгох	Компаний урд хэсэгт мод тарих, зүлэгжүүлэх	Компанийн урд талбайд 15ш мод тарих, зүлэгжүүлэх	15ш х 6,0 = 90.0 Тохижилтод 540,0	2026 оны хавар	Байгаль орчин, эвдэрсэн газрын техникийн нөхөн сэргээлт. MH85914:2008; Газар шорооны ажлын үед үржил шимт хөрсний хуулалт, хамгаалалт. MH85916:2008; Эвдэрсэн газрыг ургамалжуулах, техникийн ерөнхий шаардлага. MH85918:2023;
Ногоон байгууламжид арчилгаа тордлогоо хийх	Ногоон байгууламжийн усалгаа, арчилгаа, тордлогоо хийх	Төсөл хэрэгжих орчинд	300,0	2026 он	
Нийт		**930,0**			

Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Ангилал	Эх үүсвэрээс гарах хог хаягдлын төрөл		Код	Аюулын зэрэглэл	Жилд гарах нийт хэмжээ,	Дахин боловсруулах	Устгах	Хадгалах	Зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж, байгууллагад нийлүүлэх	Хог хаягдал зайлуулахад гарах зардал, мян.төг	Баримтлах стандарт, аргачлал
Ахуйн	Хог хаягдлыг ил задгай хаяхгүй байх				**3.5 тн**	+	**үгүй**	Зориулалтын саванд хадгалах	Хан-Уул ТҮК	960,0	Хог хаягдлын тухай хууль
	Ангилан ялгаж тус тусад нь хийх савтай болгох					+	**үгүй**	Ангилан ялгаж	Гадна талд	-	
Аюултай	Хатуу	Хортой бодисын үлдэгдэл агуулсан эсвэл бохирдсон сав, баглаа	50109*	Х	Үүсэх хэмжээг тодорхойлох боломжгүй	+	-	+		1200,0	
		Шингээгч болон шүүлтүүрийн материал, бохир алчуур,	5 02 01*	Х		-	-	+	+		
Нийт										**2160,0**	

Тайлбар

“Х”- хяналттай хог хаягдлыг тэмдэглэгээгээр

“Х” гэсэн тэмдэглэгээтэй хог хаягдлыг аюултай хог хаягдалд хамруулах эсэхийг шинжилгээгээр тогтоох ба аюултай шинж чанар үзүүлэгч бүрэлдэхүүнийг босго түвшинтэй тэнцүү болон түүнээс дээш хэмжээгээр агуулж байвал “аюултай” гэж үзнэ.

Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Болзошгүй аюул, осол сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Нэгжийн өртөг (мян.төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Байгалийн давагдашгүй хүчин зүйлээс болж гал гарч химийн бодис галд өртөж шатвал аюултай нөхцөл байдал үүснэ.	Байгаль хамгаалал, болзошгүй түймрээс урьдчилан сэргийлэх талаар ухуулга, сурталчилгааны самбар хийж байрлуулан, тухай бүрд нь шинэчилж байх	100,0	2026 онд	-
	Галын багаж хэрэгсэл авч ашиглахад бэлэн байдлаар байрлуулах (амьсгалын нэг бүрийн хамгаалалтын аппарат, галын хор, гал унтраагч, усан шүршүүр, гал унтраах хуурай хэрэгсэл, хөөс, нүүрсхүчлийн хий гэх мэт)	100,0	2026 онд	МЮ 5566:2005. Аж ахуйн нэгж байгууллагад зайлшгүй байх гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн шаардлага
	Бодис урвалжуудын хор аюулын зэргийг харуулсан тэмдэг, тэмдэглэгээг монгол тайлбараар дэлгэрэнгүй хийх	50,0	2026 онд	МНБ5029:2011. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Химийн хорт болон аюултай бодисын шошго, анхааруулах тэмдэг.
Химийн бодис их хэмжээгээр асгарвал аюултай нөхцөл байдал үүснэ.	Ослын үед ашиглах гар болон автомат ажиллагаатай дуут дохиололтой болох	250,0	2026 онд	МҮ 6458:2014. “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, Химийн хорт болон аюултай бодис бүтээгдэхүүний агуулах”
	Нэг бүрийн хамгаалах хэрэгсэл*, хоосон сав, бортого, бортого онгойлгогч, наалддаг шошго, металл юүлүүр, хүрз, хогийн шүүр, хориглох тэмдэг болон тууз зэрэг багаж хэрэгслийг бэлэн байлгах	100,0	2026 онд	
	Болзошгүй тохиолдлоор химийн бодис асгарсан тохиолдолд хэрэглэх зориулалтын шингээгч, хүнсний сод, хуурай элс, шороо,тогтворжуулагч, үртэс гэх мэт материалуудыг ажлын талбарт бэлэн байлгах	-	2026 онд	Тухайн бодисын хор аюулгүйн лавлах мэдээлэл
Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний нийт зардал		**600,0**		

БОМТ-г хэрэгжилтийн нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах

БОМТ, түүний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх оршин суугчид, оролцогч талууд	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээний агуулга	Хугацааны тов	Хэлэлцүүлгээр санал авах чиглэл	Зохион байгуулах газар
Нийслэлийн БОГазарт	Уулзалт, санал асуулга	БОМТ болон Хяналт, шинжилгээний биелэлтийг тайлагнах	11-р сар	Нийслэлийн БОГ-ын дүгнэлт	Хан-Уул дүүргийн 20-р хороо
БОУАӨЯ-ны ХБОБТГ-т	-	Тайланг хүлээн авсан актыг БОМТөлөвлөгөөтэй хамт хүргүүлэх	12-р сар	-	-

Төсөл хэрэгжүүлэх тухайн жилийн төлөвлөгөөний зардалд 11,530,000 төгрөг төлөвлөсөн.

ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Тухайн төслийг хэрэгжүүлснээс үүдэн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг тухай бүр илрүүлэх, бууруулах, арилгах зорилгоор байгаль орчны төлөв байдал, шинээр үүсэн бий болсон нөхцөл байдалд ажиглалт, хяналт явуулах үйл ажиллагааны удирдамжийг **“орчны хяналт шинжилгээний хөтөлбөр”** гэнэ.

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тухайн төслөөс байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг /ус, хөрс, ургамал гэх мэт/ тус бүрд гарах бохирдол, аливаа өөрчлөлтийг хянах шинжилгээний арга аргачлал, хяналт шинжилгээ хийх хугацаа, сорьц авах болох хэмжилт хийх цэгийн байршил, баримтлах стандартууд зэргийг тодорхойлно.

Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөр нь төслийг хэрэгжүүлэх явцад үүссэн сөрөг нөлөөлөл, түүнийг бууруулах үйл ажиллагаа ямар үр дүнтэй байгааг илтгэх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний үндэслэлийг боловсруулах, байгаль хамгаалах төлөвлөгөөг улам боловсронгуй болгох, байгаль орчноо хамгаалах, орон нутгийн захиргаа, хяналтын болон нутгийн оршин суугчдад бодитой мэдээлэл өгөхөд чухал ач холбогдолтой. ОХШХ нь БОХТ-тэйгээ нягт уялдсан бөгөөд байгаль орчныг хамгаалахаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний үр дүнг илэрхийлж, уг авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ үр ашигтай байгаа эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдэд юуг анхаарах шаардлагатайг зааж өгнө.

Байгаль орчныг хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай Монгол Улсын хуулиудын дагуу батлагдсан арга, аргачлалаар, итгэмжлэгдсэн тоног төхөөрөмжөөр байгаль орчны хяналт шинжилгээний ажлыг явуулах шаардлагатай.

Тухайн жилд хийсэн хяналт шинжилгээний үр дүнгүүдийг жил бүрийн 12 дугаар сарын 1-ний дотор холбогдох төрийн захиргааны төв байгууллага /Байгаль орчин, ногоон хөгжлийн яам/-д хүргүүлэн хянуулж, дараа оныхоо төлөвлөгөөг батлуулж ажиллах ёстой.

Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлэх, батлагдсан арга, аргачлалаар дээжлэлт, хэмжилт хийх, холбогдох нарийвчлал, тохиргоог хангасан багаж тоног төхөөрөмжөөр шинжилгээг хийлгэх, үр дүнг шаардагдах нэгжийн системээр гаргах зэрэг бүхий л үйл ажиллагааг “Блюскай кашемир” ХХК хариуцах болно.

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналт шинжилгээ хийх байршил	Хугацаа ба давтамж	Шаардагдах зардал (мян.төгрөг)	Баримтлах арга, аргачлал, стандарт, шаардлагууд
1. Агаарын чанар					
1.1	Агаарын бохирдлын ($H0_2$, $8O_2$, CO, Тоос) шинжилгээ хийлгэж байх	Үйлдвэр дотроо	Агаарын найрлага: Улирал бүр	Багажийн түрээсийн зардал: 1 багаж 40.0 х жилд 2 удаа* **НИЙТ 80,0**	МҮ 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага, МҮ 3384:1982 Сорьц авахад тавих ерөнхий шаардлага, МҮ 4048:1988 Тоосны хэмжээг тодорхойлох жингийн арга МҮ 0017-2-5-11:1988 Агаар дахь азотын давхар ислийн хэмжээг тодорхойлох фотоколориметрийн арга, МҮ 5002:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага МҮ 180 226:2003 Дуу чимээ- хэвийн норм, түвшиний хэмжээ
1.2	Дуу шуугиан, чичиргээ		Улирал бүр	Багажийн түрээсийн зардал: 1 багаж 30.0 х жилд 2удаа **НИЙТ 60,0**	
2. Хөрсний бохирдол					
2.1	Хөрсний морфологи бичиглэл, pH, цахилгаан дамжуулалт, давс %, ялзмагийн агууламж %, шим тэжээлийн элемент ($H0_3$, P_2O_5, K_2O), хөрсний механик бүрэлдэхүүн, нүүрс устөрөгчийн нэгдлүүд, кадмий, хром, кобальт, зэс, хар тугалга, манган, никель, цайр	Төслийн талбайд 1 цэг сонгох /	Улирал тутамд	1цэгт х 1 дээж жилд 1удаа /27.0+28.0/ **НИЙТ 50.0** /Хөрсний химийн шинжилгээ 1 дээж -25.0 төг, хүнд металлын шинжилгээ 1 дээж- 28.0 төг/	М\8 3307:1991, МЫ8 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга, МК8 3309:1991 Хөрс. Хөрсний хялбар уусдаг давсны химийн найрлагыг тодорхойлох арга, МК8 3298:1991 Хөрс. Шинжилгээнд дээж авахад тавигдах ерөнхий шаардлага МК8 180 11047:2001 Хөрсний чанар. Хөрсний усан орчны хандмалд кадмий, хром, кобальт, зэс, хар тугалга, манган, никель, цайрыг тодорхойлох. Дөлний болон цахилгаан дулааны атомын шингээлтийн спектрометрийн арга МҮ 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга МҮ 5850:2019 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
3. Усны шинжилгээ					

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналт шинжилгээ хийх байршил	Хугацаа ба давтамж	Шаардагдах зардал (мян.төгрөг)	Баримтлах арга, аргачлал, стандарт, шаардлагууд
3.1	Бохирын шугамын усанд шинжилгээ хийлгэх	Үйлдвэр дотроо	Улирал бүр	Бохирын шинжилгээ улиралд 1 удаа х /45.0/ **Нийт 180.0**	МК86561:2015 бохир усыг шугамд нийлүүлэх стандартын дагуу
Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх ажлын 1 жилийн нийт зардлын дүн					